



Хэвлэлийн мэдээ

2016 оны 6-р сарын 20-ний өдөр, Даваа гараг

Холбогдох утас:

9710-9009

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
АНУ-руу Хийх Бизнес Аялалыг Гуравдахь Жилдээ Зохион Байгуулж Байна**

Вашингтон, Д.С. - 2016 оны 6-р сарын 20-24-нд Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам) нь АНУ-руу Хийх Бизнес Аялалыг гуравдахь жилдээ зохион байгуулж байна. АмЧам Монголын төлөөлөгчид Бизнес аялалд оролцон Америк-Монголын худалдааны хамтын ажиллагааг хариуцан ажилладаг Америкийн төрийн албан тушаалтнуудтай уулзаж танилцахаас гадна Америкийн бизнесүүдтэй холбоо тогтоож бизнесийн бодитой хамтын ажиллагаа эхлүүлэх боломжийг судлах юм.

Бизнес Аялалын хүрээнд АмЧам Монгол нь “Монгол улс эргэн ирлээ: Америкийн хувийн хэвшлийнхэнд гарч буй боломжууд” сэдэвт дугуй ширээний уулзалтыг 2016 оны 6-р сарын 24-ний Баасан гарагт Вашингтон хотод байрлах Америкийн Худалдааны Танхим дээр зохион байгуулах юм. Дугуй ширээний уулзалтад АНУ-ын төрийн албан тушаалтнууд, Америкийн Худалдааны Яам, АНУ дахь Монгол улсын Элчин Сайдын Яамны төлөөлөгчид, АмЧам Монголын бизнесийн салбарын төлөөлөл болон бусад холбогдох талууд оролцоно.

Төлөөлөгчид мөн Ази Номхон Далайн Орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөлийн Хаалга тогших (Doorknock) уулзалтууд буюу Ази-Номхон далайн бүсэд бизнесийн харилцааг өргөжүүлэх талаар мэргэжлийн судалгааны байгууллагууд, судлаачид (тинк-танк), АНУ-ын хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын байгууллагын төлөөлөл болон мэргэжилтнүүдтэй уулзаж санал солилцох юм.

Мөн Бизнес Аялалын Төлөөлөгчид нь АНУ-ын Конгресс, Худалдааны Төлөөгчийн Газар, Худалдааны Яам, Худалдааны Танхим, Гадаад Хэргийн Яам, мэргэжлийн судалгааны байгууллагууд болон судлаачид (тинк-танк) болон томоохон санхүүгийн байгууллагууд болох Эксим банк болон Америкийн Хувийн Хөрөнгө Оруулалтын Корпорацитай тус тус уулзалт хийх юм.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны оффис юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.